



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/14

Ховд

Тогтоолын хэрэгжилт хангах  
тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Улсын нөөцөөс өвс тэжээл олгох, тэжээл нөхөн бүрдүүлэх тухай” 212 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр тогтоолын 9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймаг дахь Улсын нөөцийн 100 дугаар салбараас үнэгүй олгох 30.085.600 төгрөгний үнэ бүхий 100 тн өвсний тоо хэмжээ, хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Улсын нөөцөөс үнэгүй олгосон өвсийг малчид, мал бүхий иргэдэд олгох ажлыг удирдлагаар хангаж, тэгш хүртээмжтэйгээр хуваарилан олгохыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Б.Алтанбадралт/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2021 оны  
01 дүгээр сарын 18-ны өдрийн А/14  
дүгээр захирамжийн хавсралт

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 100 ДУГААР САЛБАРААС ӨВӨЛЖИЛТ  
ХҮНДЭРСЭН СУМДАД ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ОЛГОХ 100 ТН ӨВСНИЙ  
ХУВААРИЛАЛТ

д/д	Сумдын нэрс	Тоо хэмжээ /боодол/
1	Мөнххайрхан	750
2	Мөст	1000
3	Дуут	600
4	Цэцэг	700
5	Манхан	400
	Дарви	350
6	Зэрэг	750
7	Жаргалант	200
8	Ховд сум, Баянбулаг баг	200
9	Зэрлэг амьтан хамгаалах арга хэмжээнд	100
10	НИЙТ	5000

-oOo-